



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

ХЭНТИЙ АЙМГИЙН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН ДАРГА Л.МЭНДБАЯР
ТАНАА

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2017.03.22 № 06/126
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа зөрчлийг эс тооцвол Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал


Цалингийн зардлаас 1.3 сая төгрөгийн тэтгэмжийг анхан шатны баримтгүй, 6.9 сая төгрөгийн ур чадварын нэмэгдэлийг хавгайруулан олгосон, цалингийн зардлаас зориулалт бусаар 13.3 сая төгрөгийн тэтгэмж, 4.6 сая төгрөгийн шагнал олгосон, норм норматив баримтлалгүй 6.24 сая төгрөгийн хоолны зарцуулалт хийсэн, мэдээлэл технологийн үйлчилгээ зардлаас 6.8 сая төгрөгийг зориулалт бусаар, захиргаа аж ахуйн тасгийн ажилтануудад 5.7 сая төгрөгийн илүү цаг олгож төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан,

195
улсын мэдээллийн маягтын 7.4 сая төгрөгийн зардлыг бичиг хэргийн зардлаар, 29.8 сая төгрөгийн хангамжийн материалын зардлыг аж ахуй материал худалдан авах зардлаар тус тус тайлагнасан, кассын орлогоос донорын хоолонд 1,1 сая төгрөгийг зарцуулсан, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, УИХ-ын 29 дүгээр тогтоолыг зөрчин 10 ажилтны цалингийн шатлалыг ахиулсан зэрэг нийт 83,1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн нь санхүүгийн тайлангийн оршин байгаа, эрх ба хэмжилт, үнэн зөв байдал, тодруулга ба толилуулга гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.



ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ХЭНТИЙ АЙМГИЙН НЭГДСЭН ЭМНЭЛГИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
сараах хаягаар харилцана уу:

ТАБ-ын Тэргүүлэх аудитор
Утас: 70562112
Цахим хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 70562147
Цахим хаяг: otuya_099@yahoo.com

Аудитор: Ц.Хатанболд
Утас: 70562147
Цахим хаяг:

ТАБ-ын хаяг
Байршил: Хэнтий аймаг Хэрлэн
сум 3-р баг АЗДТГ-ын байр
Цахим хуудас:
Khentii@audit.gov.mn

2018 оны 03 дугаар сар

Аудитын тайлан

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Менежментийн захидал
- Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

198

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд /ХЭА-2018/158/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, мөтөлбөрийн дагуу явуулав.

Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25-наас 2018 оны 02 дугаар сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитор Ц.Хатанболд хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн төсвийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2018 оны 03 дугаар сарын 05-нд ТАБ-д ирүүлсэн байна.

ТАБ аудитыг 2018 оны 3 дугаар сарын 13-наас 2018 оны 03 дугаар сарын 22-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 03 дугаар сарын 22-нд байгууллагын удирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай 16 дугаар зүйлийн 16.10 "Нэгдсэн эмнэлэг нь долоогоос доошгүй үндсэн мэргэшлээр эмнэлгийн лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээг амбулатороор болон хэвтүүлэн эмчлэх хэлбэрээр үзүүлэх байгууллага байна" гэсэн бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлэг үйл ажиллагаа явуулж байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасны

Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн дарга Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг аймгийн төрийн сангаар дамжуулан олгож байна

Төсвийн тухай хуулийн 16.5 дугаар зүйлд "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн зөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасан байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиуд бүрэн хэрэгжиж байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансад түүвэрчилсэн байдлаар аудитын 9 хяналтын горим, нарийвчилсан сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТШЗ-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байгаа бөгөөд байгууллагын дотоод хяналтын эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалтгүй байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Хэнтий аймгийн төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

200

Төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 5,8 тэрбум төгрөгийн санхүүжилт авчээ. Үүнээс урсгал зардалд 5,7 тэрбум төгрөгийг зарцуулж, үлдэгдсэн төсвийг 0,1 тэрбум төгрөгөөр хэмнэсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4-р улиралын байдлаар шалгаж үзэхэд нийт мэдээлбэл зохих 42 мэдээллээс 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 6 мэдээллийг шилэн дансны нэгдсэн системд огт мэдээлээгүй байна. Хэнтий аймаг дахь төрийн аудитын газраас Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн нийцлийн аудитаар 3,4 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан Нэгдсэн эмнэлгийн ерөнхий нягтлан бодогчид санхилгын шийтгэл ногдуулах санал хүргүүлж, Нэгдсэн эмнэлгийн даргын 2017 оны 6/261 тушаалаар сануулах арга хэмжээ авч, алдаа зөрчлөө давтан гаргахгүй байх, ажлын байрны үүрэг хариуцлагыг дээшлүүлэхийг үүрэг болгосон боловч алдаа зөрчил дахин давтагдан гарсан байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 эрсдлийг тогтоож, гүйцэтгэлийн шатанд 5 эрсдэл шинээр нэмж батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан нийт 15 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар цалингийн урьдчилгааг томилолтын урьдчилгаа дансаар тайлагнасан, мөнгөн гүйлгээний тайланд нийгмийн даатгалаас санхүүжсэн тэтгэмжийг тэтгэмжийн зардлаар, санхүүгийн үр дүнгийн тайланд малын нас дэвшилтийг хөрөнгийн зардлаар тус тус бүртгэсэн, зардлыг урьдчилж төлсөн боловч урьдчилгаа тооцоогоор тайлагнаагүй, авлагыг анхан шатны баримтгүй данс бүртгэлээс хассан, түрээсийн орлогыг дутуу тооцсон, цалингийн зардлаас тэтгэмж, ур чадварын нэмэгдэл, шагнал олгосон, норм норматив баримтлалгүй хоолны зарцуулалт хийсэн, захиргаа аж ахуйн тасгийн ажилтнуудад илүү цаг олгож төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан, улсын мэдээллийн маягтын зардлыг бичиг хэргийн зардлаар, хангамжийн материалын зардлыг аж ахуй материал худалдан авах зардлаар тус тус тайлагнасан, кассын орлогоос зарцуулалт хийсэн, дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй, 10 ажилтны цалингийн шатлалыг ахиулсан, тендер зохион байгуулаагүй, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчлүүд илэрсэн байна. Энэ нь санхүүгийн тайлангийн оршин байгаа, эрх ба хэмжилт, үнэн зөв байдал, тодруулга ба толилуулга гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай гэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Улсын мэдээллийн маягтын 7.4 сая төгрөгийн зардлыг бичиг хэргийн зардлаар, 29.8 сая төгрөгийн хангамжийн материалын зардлыг аж ахуй материал худалдан авах зардлаар тус тус тайлагнасан.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

2. Донорын хоолны 1,1 сая төгрөгийн зардлыг кассаас шууд зарцуулсан

21

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

3. Цалингийн зардлаас зориулалт бусаар 13.3 сая төгрөгийн тэтгэмж, 4.6 сая төгрөгийн шагнал олгосон, норм норматив баримтлалгүй 6.2 сая төгрөгийн хоолны зарцуулалт хийсэн, мэдээлэл технологийн үйлчилгээ зардлаас 6.8 сая төгрөгийг зориулалт бусаар, захиргаа аж ахуйн тасгийн ажилтнуудад 5.7 сая төгрөгийн илүү цаг, ажилтнуудад 6.9 сая төгрөгийн ур чадварын нэмэгдлийг тодорхой шалгуур үзүүлэлтгүйгээр хавтгайруулан олгож төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан зөрчил илэрсэн

Шийдвэрлэсэн: Зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлэв.

4. Шуудан холбооны зардлыг шалгахад 242,6 мянган төгрөгийн зардлыг урьдчилж төлсөн боловч урьдчилгаа тооцоогоор тайлагнаагүй байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийв.

5. Мөнгөн гүйлгээний тайланд 67.5 сая төгрөгийн нийгмийн даатгалаас санхүүжсэн тэтгэмжийг тэтгэмжийн зардлаар 3150.0 мянган төгрөгийн цалингийн урьдчилгаа томилолтын урьдчилгаа дансаар, санхүүгийн үр дүнгийн тайланд 13.4 сая төгрөгийн малын нас дэвшилтийг хөрөнгийн зардлаар тус тус бүртгэсэн байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийв.

6. Түрээсийн орлогын гүйцэтгэлийг шалгахад 113,4 мянган төгрөгийн түрээс дутуу тооцсон, Түрээсийн орлогын 30 хувийг түрээслэгч шууд төвлөрүүлэхээр гэрээнд тусгасан нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 102 тогтоолоор батлагдсан түрээсийн гэрээний үлгэрчилсэн загвартай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

7. УИХ-ын 29 дүгээр тогтоолын хэрэгжилтийг шалгахад нэр бүхий 10 ажилтны цалингийн шатлалыг ахиулсан байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

8. ТБОНӨХБАҮХАТ хуулийн хэрэгжилтийг шалгахад 6 төрлийн зардалд 209,7 сая төгрөгийн тендерийг зарлаагүй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

9. Авлага, өр төлбөрийн үлдэгдлийг тулган баталгаажуулахад насжилт өндөртэй 1,2 сая төгрөгийн авлагыг анхан шатны баримтгүй данс бүртгэлээс хассан байна.

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийв.

10. Мөнгөн хөрөнгийн гүйлгээнээс цалингийн зардлыг тулган баталгаажуулахад 1.4 сая төгрөгийн тэтгэмжийг анхан шатны баримтгүй олгосон зөрчил илэрсэн.

Шийдвэрлэсэн: Төлбөрийн акт тогтоов.

11. Дотоод хяналтын талаар хийгдсэн ажлыг судлаж үзэхэд ажлын хэсэг байгуулж ажиллах журмыг баталсан боловч тодорхой ажил хийгдээгүй байна.

202

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

12. Цалингийн зардлыг анхан шатны баримтаас тулган баталгаажуулахад сар бүрийн нягтлан бодох бүртгэлтэй тохирохгүй зөрүүтэй байна. Үр дүнгийн тайланд 1,4 сая төгрөг, мөнгөн гүйлгээний тайланд 0,1 сая төгрөгийн зөрүүтэй байна.

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын

талаарх тайлбар:

Улсын мэдээллийн маягтын 7.4 сая төгрөгийн зардлыг бичиг хэргийн зардлаар, 29.8 сая төгрөгийн хангамжийн материалын зардлыг аж ахуй материал худалдан авах зардлаар тус тус тайлагнасан материаллаг зөрчил илэрсэн боловч аудитын явцад цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас болоод санхүүгийн тайланд залруулга хийх боломжгүй байсан тул залруулаагүй, шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 27 алдаа илэрсэн нь материаллаг бус санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл байхгүй тул залруулга хийгдээгүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлэг нь 2017 оны санхүүгийн тайлангаа Төсвийн тухай хуульд заасан хугацаанд Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, аудитад шаардлагатай баримт материалыг тухай бүрд нь гаргаж өгөөгүй, хугацаа алдсан, аудитаар илэрсэн нийт алдаа зөрчлийн ихэнх хувийг нягтлан бодох бүртгэл хөтлөлттэй холбоотой байгаа нь төсөв захирагчийн ахлах нягтлан бодогчийн ажлын хариуцлага, мэргэжлийн ур чадвар хангалтгүй байгааг харуулж байна. Иймд Сангийн сайдын 2012 оны 294 тоот тушаалаар батлагдсан "Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчид тавигдах шаардлага, шалгуур журам"-ын 4 дэх хэсэгт заасан төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчийн үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2017 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад үийцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй байж болох цалингийн зардал, материалын зарцуулалтыг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 380,2 сая төгрөгийн 12 алдаа, зөрчил илэрсэн ба 85,5 сая төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулга хийж, 1,5 сая төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 43,6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 249,6 сая төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газраас аудит хийж хязгаалалттай санал дүгнэлт, 6 зөвлөмж өгсний 1 зөвлөмжийг 50 хувь бусад зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Хязгаарлалттай санал дүгнэлт

Цалингийн зардлаас 1.3 сая төгрөгийн тэтгэмжийг анхан шатны баримтгүй, 6.9 сая төгрөгийн ур чадварын нэмэгдлийг хавтайруулан олгосон, цалингийн зардлаас зориулалт бусаар 13.3 сая төгрөгийн тэтгэмж, 4.6 сая төгрөгийн шагнал олгосон, норм норматив баримтлалгүй 6.24 сая төгрөгийн хоолны зарцуулалт хийсэн, мэдээлэл технологийн

Зөрчилгээ зардлаас 6.8 сая төгрөгийг зориулалт бусаар, захиргаа аж ахуйн тасгийн
 үйлчилгээний зардлуудад 5.7 сая төгрөгийн илүү цаг олгож төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан,
 төсвийн мэдээллийн маягтын 7.4 сая төгрөгийн зардлыг бичиг хэргийн зардлаар, 29.8 сая
 төгрөгийн хангамжийн материалын зардлыг аж ахуй материал худалдан авах зардлаар тус
 тус тайлагнасан, кассын орлогоос донорын хоолонд 1,1 сая төгрөгийг зарцуулсан, дотоод
 аудитыг хэрэгжүүлээгүй, УИХ-ын 29 дүгээр тогтоолыг зөрчин 10 ажилтны цалингийн
 батлалыг ахиулсан зэрэг нийт 83,1 сая төгрөгийн алдаа зөрчил илэрсэн нь санхүүгийн
 тайлангийн оршин байгаа, эрх ба хэмжилт, үнэн зөв байдал, тодруулга ба толилуулга гэсэн
 батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн 2017 оны 12
 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн
 зөрчлөлт, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад
 тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн
 Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв,
 шударга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 16 хуудас, хавсралтууд 5 хуудас, байгууллагын
 санал 1 хуудсыг тус тус хавсаргав.

Аудитын тайланг

Хянасан:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 АУДИТЫН МЕНЕЖЕР



Ч.ЭРДЭНЭБААТАР
 Д.ОЮУНТУЯА
 Ц.ХАТАНБОЛД

Бэлтгэсэн:

АУДИТОР

Огноо: 2018.03.22



ХЭНТИЙ АЙМГИЙН НЭГДСЭН
ЭМНЭЛГИЙН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
 Нягтлан бодох бүртгэлийн талаар3
 Асуудал 2
 Төсвийн зарцуулалтын талаар 4
 Асуудал 3
 Дотоод хяналтын талаар.....5

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

Тэргүүлэлт:

1. Улсын мэдээллийн маягтын 7.4 сая төгрөгийн зардлыг бичиг хэргийн зардлаар, 29.8 сая төгрөгийн хангамжийн материалын зардлыг аж ахуй материал худалдан авах зардлаар тус тус тайлагнасан нь Сангийн сайдын 2015 оны 7 тоот тушаалын 2 дугаар хавсралтыг зөрчсөн ба үнэн зөв байдал, оршин байгаа, толилуулга ба илчлэл тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.
2. Цалингийн зардлыг анхан шатны баримтаас тулган баталгаажуулахад сар бүрийн нягтлан бодох бүртгэлтэй тохирохгүй зөрүүтэй байна. Үр дүнгийн тайланд 1,4 сая төгрөг, мөнгөн гүйлгээний тайланд 0,1 сая төгрөгийн зөрүүтэй зөрчил илэрсэн. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтыг тус тус зөрчиж үнэн зөв байдал, оршин байгаа, толилуулга ба илчлэл тодруулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Зөвлөмж:

1. Сангийн сайдын 2015 оны 7 тоот тушаалаар батлагдсан эдийн засгийн ангилалыг мөрдөж ажиллах
2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.7 "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

Эрсдэл:

НББ-ийн тухай хуулийг хэрэгжүүлэхгүй байх
Дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлэх

Төсвийн захирагчийн хариу:

Илрүүлэлт:

1. Донорын хоолны 1,1 сая төгрөгийн зарцуулалтыг хийхдээ кассаас шууд бэлэн мөнгө зарцуулсан нь Сангийн сайдын 2012 оны 276 тушаалаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг зөрчсөн байна Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байдал, оршин байгаа батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.
2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан босго үнийг давсан тээвэр шатахуун, хог хаягдал зайлуулах, бага үнэтэй түргэн элэгдэл зүйлс, нормын хувцас, багаж техник хэрэгсэл, урсгал засварын нийт 209,7 сая төгрөгийн зардалд тендер шалгаруулалт зохион байгуулаагүй нь ТБОНӨХБАҮХАТ хууль, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг зөрчсөн байна Энэ нь эрх ба үүрэг, үнэн зөв байдал, оршин байгаа, толилуулга ба илчлэл тодруулга батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.
3. Нэр бүхий 10 ажилтны цалингийн шатлалыг ахиулсан нь УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолыг зөрчсөн байна Энэ нь эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Эрсдэл:

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэхгүй байх
Дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлэх

Зөвлөмж:

1. Сангийн сайдын 2012 оны 276 тушаалаар батлагдсан Төсвийн байгууллагын мөнгөн кассын ажиллагааны журмыг мөрдөж жижиг мөнгөн сан ажиллуулах
2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д заасан босго үнийг давсан төсөвт ертөгтэй бараа ажил үйлчилгээнд холбогдох тендер шалгаруулалтыг зохион байгуулж төсвийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх
3. УИХ-ын 2017 оны 29 дүгээр тогтоолыг бүрэн хэрэгжүүлж ажиллах

Төсвийн захирагчийн хариу:

Илрүүлэлт:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг 4-р улирлын байдлаар шалгахад нийт мэдээлбэл зохих 42 мэдээллээс 21 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, 6 мэдээллийг огт мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтыг зөрчсөн ба эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.
2. Нэгдсэн эмнэлгийн даргын 2017 оны А/10 тоот тушаалаар дотоод хяналтын нэгжийг байгуулж дотоод хяналтын ажлын хэсгийн бүрэлдэхүүн ажиллах журмыг баталсан боловч дотоод хяналтын ажил огт хийгдээгүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалтуудыг зөрчсөн ба эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Зөвлөмж:

1. Шилэн дансны тухай хуулийг бүрэн хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол үнэн зөв мэдээлж байх
2. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1 "Аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дотоод хяналтын бодлого, удирдлага, зохион байгуулалтыг аж ахуйн нэгж, байгууллагын эрх бүхий этгээд тодорхойлно", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4 "төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх", 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

Эрсдэл:

Дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлэх

Төсвийн захирагчийн харуу:

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

АУДИТОР

БЭЛТГЭСЭН:

Огноо: 2018-03-22

2317144297
СЮА0046 9074082

Ч.ЭРДЭНЭБААТАР

Д.ОЮУНТУЯА

Ц.ХАТАНБОЛД